



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газрыг 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ӨМА-2026/025/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.Umnugovi@audit.mn](http://www.Umnugovi@audit.mn)

Өмнөговь аймаг

2026 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр  
Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn  
Аудитын менежер: Т.Хонгорзул  
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn  
Ахлах аудитор: Ж.Болормаа  
Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.02.25 № 262  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Ц.АМАРТӨГС ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Бүсчилсэн хөгжил төрийн албаны манлайлал говийн бүсийн болон төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагын томоохон зөвлөгөөнүүдийг зохион байгуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1,299,703.7 мянган төгрөгийн орон сууц, 1,024,700.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 250,432.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 183,395.5 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, 580,400.0 мянган төгрөгийн программ хангамж нэмэгдсэн байна.

4626050408

4626050408

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 113 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 88.9 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Балансын зүйл	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>4</b>	<b>1,339,900.00</b>	5,105,420.00
Банканд байгаа бэлэн мөнгө		1,339,900.00	5,105,420.00
Төгрөг		1,339,900.00	5,105,420.00
Төрийн сангийн харилцах		1,339,900.00	5,105,420.00
<b>АВЛАГА</b>	<b>5</b>	<b>300,000.00</b>	
Ажиллагчидтай холбогдсон авлага		300,000.00	
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>6</b>	<b>206,250,614.00</b>	<b>105,710,364.00</b>
Хангамжийн материал		206,250,614.00	105,710,364.00
Бичиг хэргийн материал		546,000.00	
Түлш, шатах тослох материал		46,820,000.00	37,420,000.00
Бусад хангамжийн материал		158,884,614.00	68,290,364.00
<b>НӨӨЦИЙН БАРАА</b>			<b>29,649,400.00</b>
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/			29,649,400.00
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>207,890,514.00</b>	<b>140,465,184.00</b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>7</b>	<b>16,249,407,585.87</b>	<b>18,493,023,615.55</b>
Биет хөрөнгө		14,539,073,966.16	16,190,377,769.67
Барилга, байгууламж, орон сууц		13,066,901,345.80	14,210,305,811.80
Хуримтлагдсан элэгдэл		(1,172,016,545.61)	(1,461,136,082.78)
Авто-тээврийн хэрэгсэл		1,356,967,844.50	1,735,512,633.23
Хуримтлагдсан элэгдэл		(317,044,405.61)	(180,035,069.08)
Машин тоног төхөөрөмж (компьютер)		1,413,548,962.95	1,703,328,333.35
Хуримтлагдсан элэгдэл		(449,660,423.27)	(611,163,489.23)
Тавилга, аж ахуйн эд хогшил		480,878,618.48	623,288,506.00
Хуримтлагдсан элэгдэл		(207,001,431.08)	(214,182,873.62)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс		352,200,000.00	352,200,000.00
Бусад үндсэн хөрөнгө		19,500,000.00	39,410,000.00
Хуримтлагдсан элэгдэл		(5,200,000.00)	(7,150,000.00)
Биет бус хөрөнгө		1,710,333,619.71	2,302,645,845.88
Программ хангамж		226,719,467.00	798,281,467.00
Хуримтлагдсан элэгдэл		(87,334,347.29)	(66,584,121.12)
Бусад биет бус хөрөнгө		1,570,948,500.00	1,570,948,500.00
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>16,249,407,585.87</b>	<b>18,493,023,615.55</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		<b>16,457,298,099.87</b>	<b>18,633,488,799.55</b>
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>9</b>		395,392.00
Өглөг			395,392.00
Ажилчидтай холбогдсон өглөг			395,392.00
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>			<b>395,392.00</b>
Засгийн газрын хувь оролцоо		16,457,298,099.87	18,633,093,407.55
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		6,847,153,137.04	6,847,153,137.04

Өмч: - төрийн		5,908,510,637.04	5,908,510,637.04
Хуримтлагдсан үр дүн		9,492,622,399.34	11,668,417,707.02
Өмнөх үеийн үр дүн		9,492,622,399.34	9,492,622,399.34
Тайлант үеийн үр дүн			2,175,795,307.68
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		117,522,563.49	117,522,563.49
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>16,457,298,099.87</b>	<b>18,633,093,407.55</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		<b>14,428,704,120.45</b>	<b>10,893,742,959.35</b>
Нэмэлт санхүүжилтийн орлого		1,785,935,820.45	911,524,930.04
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		534,426,691.28	615,818,248.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		321,287,885.00	59,692,217.04
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		930,221,244.17	236,014,465.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих		12,642,768,300.00	9,982,218,029.31
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		12,642,768,300.00	9,982,218,029.31
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>4,446,108,997.37</b>	<b>4,044,382,149.95</b>
Нийтлэг татварын бус орлого		4,446,108,997.37	4,044,382,149.95
Төсөв байгууллагын өөрийн орлого		62,164,889.00	89,305,990.50
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих			25,765,520.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		30,606,158.00	10,658,158.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		31,558,731.00	52,882,312.50
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		4,131,234,551.37	3,864,360,915.75
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		252,709,557.00	90,715,243.70
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2</b>	<b>18,874,813,117.82</b>	<b>14,938,125,109.30</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>15,582,622,432.01</b>	<b>11,949,060,177.85</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>13,101,471,634.03</b>	<b>9,543,162,195.96</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		<b>4,173,814,732.42</b>	<b>3,084,737,730.44</b>
Үндсэн цалин		1,910,910,713.72	1,300,552,991.19
Нэмэгдэл		1,671,739,324.75	1,286,172,818.04
Унаа хоолны хөнгөлөлт		186,730,000.00	113,742,500.00
Урамшуулал		404,434,693.95	384,269,421.21
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		<b>494,609,640.17</b>	<b>363,614,026.03</b>
Тэтгэврийн даатгал		338,859,830.19	246,814,840.83
Тэтгэмжийн даатгал		40,186,919.20	29,091,024.80
ҮОМШӨ-ний даатгал		19,957,433.11	14,311,872.47
Ажилгүйдлийн даатгал		18,308,988.05	13,886,387.00
Эрүүл мэндийн даатгал		77,296,469.62	59,509,900.93
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		<b>312,334,153.43</b>	<b>412,801,745.85</b>
Гэрэл, цахилгаан		82,498,755.82	108,395,872.05
Түлш, халаалт		189,929,013.61	287,432,073.80

Цэвэр, бохир ус		39,906,384.00	16,973,800.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>352,319,564.96</b>	<b>377,140,538.19</b>
Бичиг хэрэг		49,896,850.00	57,127,573.00
Тээвэр, шатахуун		226,747,819.73	253,069,975.19
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		35,393,833.23	34,999,340.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		1,095,000.00	174,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		39,186,062.00	31,769,650.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>254,875,537.99</b>	<b>377,199,023.95</b>
Урсгал засвар		254,875,537.99	377,199,023.95
<b>Томилолт, зочны зардал</b>		<b>86,633,310.00</b>	<b>120,402,210.00</b>
Дотоод албан томилолт		86,633,310.00	120,402,210.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>741,082,834.50</b>	<b>679,452,764.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		721,095,466.50	653,290,446.00
Даатгалын үйлчилгээ		949,500.00	925,560.00
Тээврийн хэрэгслийн татвар		917,647.00	994,715.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо		198,500.00	75,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ		1,120,000.00	8,118,000.00
Газрын төлбөр		16,801,721.00	16,049,043.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>6,685,801,860.56</b>	<b>4,127,814,157.50</b>
Бараа үйлчилгээний бусад зардал		5,929,776,580.00	2,923,487,430.70
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		13,022,250.00	152,962,652.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		743,003,030.56	1,051,364,074.80
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>2,481,150,797.98</b>	<b>2,405,897,981.89</b>
Бусад урсгал шилжүүлэг		718,507,167.82	17,496,040.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		227,641,000.00	
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		184,515,527.00	
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		306,350,640.82	17,496,040.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		1,762,643,630.16	2,388,401,941.89
Төвлөрүүлэх шилжүүлэг		1,762,643,630.16	2,388,401,941.89
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3</b>	<b>15,582,622,432.01</b>	<b>11,949,060,177.85</b>
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		3,292,190,685.81	2,989,064,931.45
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		1,818,800,273.68	813,269,623.77
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		1,818,800,273.68	813,269,623.77
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		-1,818,800,273.68	-813,269,623.77
<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>		<b>1,473,390,412.13</b>	<b>2,175,795,307.68</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>17,737,725,872.71</b>	<b>10,930,166,637.35</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,309,021,752.26</b>	<b>36,423,678.00</b>
Нийтлэг татварын бус орлого	3,309,021,752.26	36,423,678.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	30,606,158.00	36,423,678.00

Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		25,765,520.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,606,158.00	10,658,158.00
Бусад орлого	3,278,415,594.26	
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>14,428,704,120.45</b>	<b>10,893,742,959.35</b>
Нэмэлт санхүүжилтийн орлого	1,785,935,820.45	911,524,930.04
ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	534,426,691.28	615,818,248.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	321,287,885.00	59,692,217.04
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	930,221,244.17	236,014,465.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	12,642,768,300.00	9,982,218,029.31
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	12,642,768,300.00	9,982,218,029.31
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>17,645,180,692.71</b>	<b>10,735,394,617.35</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>17,645,180,692.71</b>	<b>10,735,394,617.35</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>15,164,029,894.73</b>	<b>8,329,496,635.46</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>4,300,049,073.81</b>	<b>3,084,042,338.44</b>
Үндсэн цалин	1,965,841,028.77	1,299,857,599.19
Нэмэгдэл	1,735,616,351.09	1,286,172,818.04
Унаа хоолны хөнгөлөлт	194,157,000.00	113,742,500.00
Урамшуулал	404,434,693.95	384,269,421.21
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>509,122,518.04</b>	<b>363,614,026.03</b>
Тэтгэврийн даатгал	349,022,214.90	246,814,840.83
Тэтгэмжийн даатгал	41,466,510.97	29,091,024.80
ҮОМШӨ-ний даатгал	20,584,029.00	14,311,872.47
Ажилгүйдлийн даатгал	18,797,849.15	13,886,387.00
Эрүүл мэндийн даатгал	79,251,914.02	59,509,900.93
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>313,270,228.43</b>	<b>412,801,745.85</b>
Гэрэл, цахилгаан	83,434,830.82	108,395,872.05
Түлш, халаалт	189,929,013.61	287,432,073.80
Цэвэр, бохир ус	39,906,384.00	16,973,800.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>375,229,307.96</b>	<b>362,523,694.49</b>
Бичиг хэрэг	49,428,850.00	56,000,400.00
Тээвэр, шатахуун	250,125,562.73	239,580,304.49
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	35,393,833.23	34,999,340.00
<b>Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал</b>	<b>1,095,000.00</b>	<b>174,000.00</b>
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	39,186,062.00	31,769,650.00
Эд хогшил, урсгал засварын зардал	254,875,537.99	377,199,023.95
Урсгал засвар	254,875,537.99	377,199,023.95
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>86,633,310.00</b>	<b>120,402,210.00</b>
Дотоод албан томилолт	86,633,310.00	120,402,210.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>741,082,834.50</b>	<b>679,452,764.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	721,095,466.50	653,290,446.00
Даатгалын үйлчилгээ	949,500.00	925,560.00
Тээврийн хэрэгслийн татвар	917,647.00	994,715.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	198,500.00	75,000.00

Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,120,000.00	8,118,000.00
Газрын төлбөр	16,801,721.00	16,049,043.00
Бараа үйлчилгээний бусад зардал	8,583,767,084.00	2,929,460,832.70
Бараа үйлчилгээний бусад зардал	8,570,744,834.00	2,776,498,180.70
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,022,250.00	152,962,652.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,481,150,797.98</b>	<b>2,405,897,981.89</b>
Бусад урсгал шилжүүлэг	718,507,167.82	17,496,040.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	227,641,000.00	
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	184,515,527.00	
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	306,350,640.82	17,496,040.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,762,643,630.16	2,388,401,941.89
Төвлөрүүлэх шилжүүлэг	1,762,643,630.16	2,388,401,941.89
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>92,545,180.00</b>	<b>194,772,020.00</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>91,205,280.00</b>	<b>191,006,500.00</b>
Дотоод эх үүсвэрээр	91,205,280.00	191,006,500.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	91,205,280.00	191,006,500.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-91,205,280.00	-191,006,500.00
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>1,339,900.00</b>	<b>3,765,520.00</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,339,900.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		5,105,420.00

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
1	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,847,153,137.04	117,522,563.49	9,492,622,399.34	16,457,298,099.87
2	Тайлант үеийн үр дүн			2,175,795,307.68	2,175,795,307.68
3	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,847,153,137.04	117,522,563.49	11,668,417,707.02	18,633,093,407.55

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
<b>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>11,868,688,300.00</b>	<b>7,598,829,857.78</b>	<b>4,269,858,442.22</b>	<b>64</b>
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>11,868,688,300.00</b>	<b>7,598,829,857.78</b>	<b>4,269,858,442.22</b>	<b>64</b>
Орон нутгийн төсвөөс	11,868,688,300.00	7,598,829,857.78	4,269,858,442.22	64
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	15,000,000.00	10,658,158.00	4,341,842.00	71.1
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,000,000.00	10,658,158.00	4,341,842.00	71.1
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>11,883,688,300.00</b>	<b>7,609,488,015.78</b>	<b>4,274,200,284.22</b>	<b>64</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>11,883,688,300.00</b>	<b>7,609,488,015.78</b>	<b>4,274,200,284.22</b>	<b>64</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>11,525,824,400.00</b>	<b>7,595,741,975.78</b>	<b>3,930,082,424.22</b>	<b>65.9</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>3,149,357,300.00</b>	<b>2,773,583,451.15</b>	<b>375,773,848.85</b>	<b>88.1</b>
Үндсэн цалин	1,474,943,000.00	1,267,313,800.39	207,629,199.61	85.9
Нэмэгдэл	1,369,744,300.00	1,278,036,868.36	91,707,431.64	93.3
Унаа хоолны хөнгөлөлт	176,790,000.00	101,362,500.00	75,427,500.00	57.3

Урамшуулал	127,880,000.00	126,870,282.40	1,009,717.60	99.2
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>393,669,500.00</b>	<b>326,603,362.68</b>	<b>67,066,137.32</b>	<b>83</b>
Тэтгэврийн даатгал	267,695,200.00	221,771,890.71	45,923,309.29	82.8
Тэтгэмжийн даатгал	31,493,600.00	26,144,584.82	5,349,015.18	83
ҮОМШӨ-ний даатгал	15,746,800.00	12,838,652.42	2,908,147.58	81.5
Ажилгүйдлийн даатгал	15,746,800.00	12,440,035.85	3,306,764.15	79
Эрүүл мэндийн даатгал	62,987,100.00	53,408,198.88	9,578,901.12	84.8
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>493,907,200.00</b>	<b>412,801,745.85</b>	<b>81,105,454.15</b>	<b>83.6</b>
Гэрэл, цахилгаан	119,955,400.00	108,395,872.05	11,559,527.95	90.4
Түлш, халаалт	322,946,600.00	287,432,073.80	35,514,526.20	89
Цэвэр, бохир ус	51,005,200.00	16,973,800.00	34,031,400.00	33.3
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>502,886,100.00</b>	<b>361,255,257.49</b>	<b>141,630,842.51</b>	<b>71.8</b>
Бичиг хэрэг	57,707,700.00	56,000,400.00	1,707,300.00	97
Тээвэр, шатахуун	238,419,900.00	238,311,867.49	108,032.51	100
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	39,272,500.00	34,999,340.00	4,273,160.00	89.1
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	174,000.00	1,026,000.00	14.5
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	166,286,000.00	31,769,650.00	134,516,350.00	19.1
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>818,844,500.00</b>	<b>510,470,069.41</b>	<b>308,374,430.59</b>	<b>62.3</b>
Багаж, техник, хэрэгсэл	296,400,000.00	190,706,600.00	105,693,400.00	64.3
Тавилга	2,000,000.00	299,900.00	1,700,100.00	15
Урсгал засвар	520,444,500.00	319,463,569.41	200,980,930.59	61.4
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>154,654,400.00</b>	<b>103,536,210.00</b>	<b>51,118,190.00</b>	<b>67</b>
Дотоод албан томилолт	154,654,400.00	103,536,210.00	51,118,190.00	67
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>859,775,400.00</b>	<b>679,452,764.00</b>	<b>180,322,636.00</b>	<b>79</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	830,400,000.00	653,290,446.00	177,109,554.00	78.7
Даатгалын үйлчилгээ	1,003,400.00	925,560.00	77,840.00	92.2
Тээврийн хэрэгслийн татвар	1,072,000.00	994,715.00	77,285.00	92.8
Тээврийн хэрэгслийн оношилгоо	400,000.00	75,000.00	325,000.00	18.8
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,900,000.00	8,118,000.00	782,000.00	91.2
Газрын төлбөр	18,000,000.00	16,049,043.00	1,950,957.00	89.2
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,152,730,000.00</b>	<b>2,428,039,115.20</b>	<b>2,724,690,884.80</b>	<b>47.1</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	4,852,730,000.00	2,275,076,463.20	2,577,653,536.80	46.9
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000,000.00	152,962,652.00	147,037,348.00	51
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>357,863,900.00</b>	<b>13,746,040.00</b>	<b>344,117,860.00</b>	<b>3.8</b>
Бусад урсгал шилжүүлэг	357,863,900.00	13,746,040.00	344,117,860.00	3.8
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	55,000,000.00		55,000,000.00	
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	152,863,900.00		152,863,900.00	
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	150,000,000.00	13,746,040.00	136,253,960.00	9.2
<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>11,883,688,300.00</b>	<b>7,609,488,015.78</b>	<b>4,274,200,284.22</b>	<b>64</b>
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>		<b>100</b>
Төсвийн байгууллага	1	1		100

АЖИЛЛАГСДЫН ТОО	67	67	100
Удирдах ажилтан	3	3	100
Гүйцэтгэх ажилтан	64	64	100

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>911,524,930.04</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>911,524,930.04</b>
ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	615,818,248.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	59,692,217.04
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	236,014,465.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>911,524,930.04</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>911,524,930.04</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>902,761,159.68</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>310,458,887.29</b>
Үндсэн цалин	32,543,798.80
Нэмэгдэл	8,135,949.68
Унаа хоолны хөнгөлөлт	12,380,000.00
Урамшуулал	257,399,138.81
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>37,010,663.35</b>
Тэтгэврийн даатгал	25,042,950.12
Тэтгэмжийн даатгал	2,946,439.98
ҮОМШӨ-ний даатгал	1,473,220.05
Ажилгүйдлийн даатгал	1,446,351.15
Эрүүл мэндийн даатгал	6,101,702.05
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,268,437.00</b>
Тээвэр, шатахуун	1,268,437.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>57,735,454.54</b>
Урсгал засвар	57,735,454.54
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>16,866,000.00</b>
Дотоод албан томилолт	16,866,000.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>479,421,717.50</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	479,421,717.50
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>8,763,770.36</b>
Бусад урсгал шилжүүлэг	3,750,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,750,000.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох	5,013,770.36
Төвлөрүүлэх шилжүүлэг	5,013,770.36
<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>911,524,930.04</b>

**Гурав. Аудитын илрүүлэлт:** Аудитаар Санхүүгийн тайланг бэлтгэхдээ хүчингүй болсон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу бэлтгэснийг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаал "Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-тай нийцүүлэн залруулж, УСНББОУС1 " Санхүүгийн тайлангийн толилуулга"-ыг хангуулж ажиллав.

Аудитаар нийт 104,378.5 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 2,195.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 9,000.0 мянган төгрөгийн албан шаардлага, 81,345.1 мянган төгрөгийн төрийн хэмнэлтийн хуулийн цахим худалдан авах ажиллагаатай холбоотой, 11,838.4 мянган төгрөгийн дотоод хяналттай холбоотой асуудалтай 2 зөвлөмжийг хүргүүллээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 104,378.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 51,447.7 мянган төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

### **3.1 Төлбөрийн акт**

Тайлант онд албан томилолтоор ажилласан албан хаагчдад хоолны үнийн хөнгөлөлт давхардуулан 2,195.0 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "*төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх*", 5.1.3-д "*санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх*", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*" гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Давхардуулан олгосон хоолны үнийн хөнгөлөлтийг орон нутгийн төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

### **3.2 Албан шаардлага**

1. Хяналт шинжилгээний үнэлгээний хэлтэс сумдад сургалт зохион байгуулахдаа цай, хоолны зардалд 9,000.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "*хариуцлагатай байх*", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", 16 дугаар зүйлийн 16.5.2-д "*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*", 16.5.5-д "*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийн таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв

2. Тайлант онд шууд гэрээ байгуулан 548,709.7 мянган төгрөгийг хэвлэл мэдээллийн арга хэмжээнд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д "*хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох*" гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчил давтан гаргахгүй байх тухай албан шаардлагыг хүргүүлэв.

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Дотоод хяналттай холбоотой асуудал**

**1.1. Илрүүлэлт:** Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 2006 оны 392/90 дугаар тушаалыг үндэслэн төрийн захиргааны 2 албан тушаалтанд сар бүр ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэлд 7,992.3 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйл. "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх үндэслэл", 57.2.2-д "*захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон төрийн алба хаасан хугацааны, цолны, зэрэг дэвийн, докторын зэргийн нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс*", Засгийн газрын 2019 оны 09 дүгээр тогтоолын хавсралт "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-д заасантай тус тус нийцээгүй байна.

---

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Өгсөн зөвлөмж:** Төрийн захиргааны ажилтанд олгож байгаа уг нэмэгдлийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэр гаргах

**1.2.Илрүүлэлт:** Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 73 дугаар тогтоолоор төрийн албаны салбар зөвлөлийн даргад сар бүр 20 хувиар урамшуулал нийт 3,846,1 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-д *"Онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараах хэлбэрээр шагнаж, урамшуулна"*, 57 дугаар зүйлийн 57.2.2-д *"захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон төрийн алба хаасан хугацааны, цолны, зэрэг дэвийн, докторын зэргийн нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс"*, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"* гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэр гаргуулах замаар хуулийн хэрэгжилтийг хангуулах

Дээрх зөрчлийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 02 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Санхүүгийн тайланг бэлтгэхдээ хүчингүй болсон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу бэлтгэсэн байна	1	0			1	0	1	0				
	Дүн	1	0			1	0	1	0				

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
1	Албан томилолтоор ажилласан албан хаагчдад хоолны үнийн хөнгөлөлт давхардуулан 2,14 сая төгрөг олгосон	1	2,195.0	1	2,195.0								
2	Тайлан онд шууд гэрээ байгуулан 548,7 сая төгрөгийг хэвлэл мэдээллийн арга хэмжээнд зарцуулсан байна.	1	0			1	0						
3	Хяналт шинжилгээний үнэлгээний хэлтэс сумдад сургалт зохион байгуулахдаа цай, хоолны зардалд 9,0 сая төгрөг зарцуулсан	1	9,000.0			1	9,000.0						
4	Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 2006 оны 392/90 дугаар тушаалыг үндэслэн төрийн захиргааны 2 албан тушаалтанд сар бүр ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэлд 7,9 сая төгрөг олгосон	1	7,992.3					1	7,992.3				

<b>5</b>	Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 73 дугаар тогтоолоор төрийн албаны салбар зөвлөлийн даргад сар бүр 20 хувиар урамшуулал нийт 3,8 сая төгрөг олгосон	1	3,846,1					1	3,846,1				
<b>Зөрчлийн дүн</b>		<b>5</b>	<b>23,033.4</b>	<b>1</b>	<b>2,195.0</b>	<b>2</b>	<b>9,000.0</b>	<b>2</b>	<b>11,838.4</b>				
<b>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт</b>													
<b>1</b>	Тайлант онд 10 сая төгрөгөөс дээш 4 нэр төрлийн 81,3 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авахдаа цахим дэлгүүрт байршуулах хүсэлт гаргаагүй худалдан авалт хийсэн	1	81,345.1					1	81,345.1				
<b>Нийт дүн</b>		<b>6</b>	<b>104,378.5</b>	<b>1</b>	<b>2,195.0</b>	<b>2</b>	<b>9,000.0</b>	<b>1</b>	<b>93,183.5</b>				

